



**ИРАН: АТЕНА ДАЕМИ**

**ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ**



## **ЦААЗААР АВАХ ЯЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭЖ БАЙГААД ХОРИГДСОН**

Атена Даеми бусдын адилаар Иранд цаазаар авах ялыг халахыг хүсдэг. Тэрээр фэйсбүүк, твиттертээ Иран улсын цаазаар авах ялын гүйцэтгэлийн талаар шүүмжилж бичдэг, ухуулах материал тараадаг байсан. Мөн залуу эмэгтэйг цаазлах гэж байгааг эсэргүүцсэн тайван жагсаалд оролцжээ. Гэвч харамсалтай нь Иранд эдгээр энгийн зүйлсийг хийхэд маш их зориг шаарддаг. Хачирхалтай нь Атенегийн үйл ажиллагаа гэмт хэрэг үйлдсэн “нотлох баримт” болж тэрээр 7 жилийн хорих ялаар шийтгэжээ. Түүний шүүх хурал 15 минут л үргэлжилсэн ба “үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэхээр үгсэн тохирч, цугларсан” гэх хэргээр яллажээ.

Түүнд ингэж хэрцгий хандаж байгаа нь Иран улсын шударга ёсны төлөө дуугардаг хүмүүсийн эсрэг авч байгаа эрс хатуу арга хэмжээний нэг гашуун сургамж юм. Олон хүнийг шоронд хорьж, цагдан хянаж, мөрдөн шалгаж, хүчээр чимээгүй болгож байна.

Атенаг зодож, ганцаарчилан хорьж байсан ч хүний эрхийн төлөөх тэмцлээ үргэлжлүүлсээр байна. Энэ оны эхээр түүнийг чанга дэглэмтэй хорих руу шилжүүлэхийг эсэргүүцэн өлсгөлөн зарлажээ. Хорих газарт түүний эрүүл мэнд маш их дордсон байна. Атенаг нэн даруй суллахын төлөө та доорх хаягаар захидал бичээрэй.

**Ираны эрх баригчдаас Атенег суллахыг шаардан захидал бичнэ үү**

Head of the Judiciary Ayatollah Sadeqh Larijani  
c/o Permanent Mission of Iran to the United Nations in Geneva  
Chemin du Petit-Saconnex 28  
1209 Geneva  
Switzerland

Salutation: Your Excellency

**Атена Даемид эв санааны нэгдлээ илэрхийлсэн захидал бичээрэй.**

Amnesty International – International Secretariat  
c/o Iran Team  
1 Easton Street  
London WC1X 0DW  
United Kingdom

Twitter: @AtenaDaemi  
Instagram: [www.instagram.com/atenadaemi](http://www.instagram.com/atenadaemi)